



“ШИВЭЭ-ОВОО”
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2016 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

Эрх олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалтыг үндэслэн
ТОГТООХ нь:

1. Захиалагчийн урьдчилан харах боломжгүй нөхцөл байдлаар валютын ханшийн өсөлтөөс шалтгаалж дизель түлшний үнэ нэмэгдсэнтэй холбогдуулан “М Ойл групп” ХХК-тай байгуулсан СШ№40ШОХК2016/ШО-15 тоот “Дизель түлш, А-80 бензин нийлүүлэх гэрээ”-ний дизелийн түлшний 1 л тутмын үнийг 1630 /НӨАТ шингэсэн/ төгрөгөөс ихгүй нөхцлөөр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг Гүйцэтгэх захирал /О.Отгонбаатар/-т зөвшөөрсүгэй.
2. Нийлүүлэгч компанитай шинэчилэн байгуулсан гэрээний үнийг гэрээний хугацаа дуусах хүртэлх хугацаанд хатуу мөрдөж ажиллах, шаардлагатай зохицуулалтыг гэрээнд оруулахыг Гүйцэтгэх захирал /О.Отгонбаатар/-т үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолыг 2016 оны 11 сарын 24-ны өдрөөс дагаж мөрдсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ТҮМЭНЦОГТ